



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/427

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтууд, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын нээлт, баярын жагсаал, туг өргөх ёслол, хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын гүйцэтгэгчээр найруулагч, продюсер (С.Ононбат)-тай 20,000,000 (хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулан, хяналт тавьж, хүлээн авахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

2.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын нээлт, хаалт болон баярын жагсаал, туг өргөх ёслолын үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг найруулагч, продюсер (С.Ононбат)-д даалгасугай.

3.Санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” олон улсын XV их наадмыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010560